

НИЙТЛЭЛ

Монгол Улс дахь олон улс судлалын түүхэн хандлага, өнөөгийн байдал, цаашдын төлөв (ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн жишээн дээр)

Дашнямын Золбоо 

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

zolbood@mas.ac.mn

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээрээ овоглосон үе үеийн эрдэмтэн судлаачид, бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн хүндэт зочид Та бүхэндээ хүрээлэн үүсэн байгуулагдсаны 55 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж байна.

Монгол Улс дахь олон улс судлал, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч мэргэжлийн ууган байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн нь өдгөөгөөс 55 жилийн тэртээ улс орны гадаад, дотоод амаргүй нөхцөл байдлын дунд үүсэн байгуулагдаж, энэ түүхэн хугацаанд хөгжил, төлөвшлийн хэд хэдэн үе шатыг туулж иржээ.

Энэхүү илтгэлийн үндсэн зорилго нь ШУА-ийн Олон улс судлалын

хүрээлэнгийн 55 жилийн хугацаан дахь судалгааны гол үр дүнг нэгтгэн тоймлож, хүрээлэн дэх олон улс судлалын судалгааны өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар дүгнэлт, саналаа Та бүхэндээ товчлон танилцуулахад чиглэгдсэн болно.

Миний бие энэхүү үндсэн илтгэлээ та бүхэнд

Нэг. Хүрээлэн байгуулагдсан түүхэн нөхцөл

Хоёр. Хүрээлэнгийн судалгааны түүхэн хандлага

Гурав. Хүрээлэнгийн судалгааны өнөөгийн байдал, цаашдын төлөв

Дөрөв. Дүгнэлт, санал гэсэн үндсэн дөрвөн хэсэгт багтаан танилцуулахаар бэлтгэв.

Нэг. Хүрээлэн байгуулагдсан түүхэн нөхцөл

Архивын баримт түшин өгүүлэхэд 1960-аад оны эхэн үеэс дэлхийн тэргүүлэх социалист орнууд Ази,

Африкийг идэвхтэй судалж, ялангуяа Африкийн нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжилд бололцооны хэрээр



нөлөөлөх, Африкийн улс түмнийг хөрөнгөтний хөгжлийн замд оруулахыг эрмэлзэгч барууны орнуудын нөлөөг тухайн тивд аль болохоор багасгахад үйл ажиллагаагаа чиглүүлж байлаа.

Энэ үеэс БНМАУ-аас олон улсын нөхцөл байдалд дүгнэлт хийн Ази, Африк судлалын талаар ах дүү социалист орнуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний хөгжлийн түвшнээс хоцрохгүй байх чиглэлээр эрчимтэй ажиллах болов.¹

1966 оны 4 дүгээр сарын 15-23-ны өдрүүдэд Москва хотноо хуралдсан социалист орнуудын Африк судлагч эрдэмтдийн зөвлөгөөнд үндэслэн БНМАУ-ын нам төр, ШУА-аас Ази-Африк судлалын судалгааг эрчимжүүлэх зорилгоор мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага байгуулах нь зүйтэй гэдэг шийдэлд хүрсэн байна. Ингэснээр тус байгууллагыг байгуулахын өмнөх хэдэн жилд ГЯЯ, ШУА-ийн хамтарсан ажлын хэсэг гарч холбогдох албаны хүмүүс ЗХУ болон ах дүү социалист орнуудын Ази, Африк судлалын эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдээр очиж танилцан туршлага судлах, зөвлөгөө авах зэргээр нэлээд ул суурьтай ажиллаж, бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллажээ. Үүний зэрэгцээ тухайн үеийн олон улсын энэхүү нөхцөл байдалд ч ихээхэн хувирал өөрчлөлт гарав.

1960-аад оны эхэн үеэс Зөвлөлт-Хятадын харилцаа хурцадмал байдалтай болж, хоёр орон марксист-ленинист онол, дайн ба энхийн асуудал, гадаад, дотоод бодлогын чиг шугамын талаар илэрхий зөрөлдөж эхэлсэн нь

БНМАУ-БНХАУ-ын харилцаанд ч шууд нөлөөлж, харилцаа ихээхэн хүйтэрч хөндийрсөн билээ.

Энэ нөхцөл байдал нь Африкийн зэрэгцээгээр БНХАУ-ын гадаад, дотоод нөхцөл байдлын талаар шинжлэх ухааны оновчтой мэдлэг, мэдээллийг нам төрөөс зүй ёсоор шаардах болов. Ийнхүү Ази-Африк судлалын хэлтсийг анх байгуулахад /өнөөгийн ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн/ Намын Төв Хороо, ГЯЯ, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар зэрэг байгууллага бодлогын дагуу чиглүүлж ажилласан байна. Уг бэлтгэл ажлыг ШУА-ийн анхны Ерөнхийлөгч, академич Б.Ширэндэв ахалж, ШУА-ийн Эрдэм шинжилгээ, мэдээллийн тасгийн ахлагч С.Аварзэд, ГЯЯ-ны Хоёрдугаар хэлтсийн эрхлэгч П.Цэрэнцоодол, элчин сайд Лувсанчүлтэм нарын албаны хүмүүс бэлтгэл ажлын хүндийг нугалахад биечлэн оролцож, түүхэн хувь нэмэр оруулсныг архивын баримт гэрчлэн харуулж байна.²

Ийнхүү МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1968 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 03 тоот тогтоолоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн дэргэд “Ази-Африк судлалын хэлтэс”-ийг байгуулснаар дээрх бодлогын хүчин чармайлт бодит биеллээ олсон байна.

Чингэж Монголын түүх судлалын баялаг уламжлал, Монгол төрийн гадаад харилцааны замнал, сургамжид тулгуурлан өөрийн оронд олон улс судлалын биеэ даасан эрдэм шинжилгээний бие даасан бүтцийг үүсгэн байгуулсан нь манай улсын шинжлэх ухааны хөгжлийн хувьд нэг чухал үйл явдал болсон билээ.

¹ Монгол Улсын Үндэсний Төв Архив, х-467, д-2, хн-5, х.8-9

² Монгол Улсын Үндэсний Төв Архив, х-467, д-2, хн-5, х.8-9

Хоёр. Хүрээлэнгийн судалгааны түүхэн хандлага

Дээрх тогтоолын дагуу “Ази-Африк судлалын хэлтэс” нь 1968 оны 4 дүгээр сарын сүүлчээр бодитоор эмхлэн байгуулагдаж, хэлтсийн эрдэм шинжилгээний ажилтнуудын олонх нь өөр байгууллагуудаас шилжин ирж, ШУА-ийн Тэргүүлэгчдийн 5 дугаар сарын 4-ны өдрийн хурлаар батлагдан ажилдаа оржээ. Мөн дээрх хурлаас тухайн үеийн нийгмийн хөгжлийн шаардлага, олон улсын байдал, улс хоорондын харилцааны төвөгтэй байдлаас шалтгаалан “Ази-Африкийн судлалын хэлтэс”-ийг Дорно дахины судлалын хэлтэс болгон тун удалгүй өөрчлөн зохион байгуулжээ.³

Хэлтэс байгуулагдсан эхний саруудад академич Б.Ширэндэв, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, доктор Ш.Бира, Ч.Жүгдэр, М.Санждорж, Ш.Сандаг нарын зэрэг Монголын урдаа барьдаг “толгой” эрдэмтдээр цуврал лекц уншуулж байсан нь анхны эрдэм шинжилгээний ажилтнуудад судалгааны ажлын аргазүйг эзэмшүүлэх, сурах судлах сэдвийг сонгож тодруулах, эх сурвалж бичгийг судлах, материал цуглуулах, боловсруулалт хийх арга барилтай болгох зэрэг эрдмийн хамт олон жинхэнээр бүрэлдэн төлөвших, тодорхой мэдлэг мэдэгдэхүүнтэй болоход ихээхэн тус нэмэр болжээ.

МАХН-ын Төв Хорооны Гадаад харилцааны хэлтэс, Үзэл суртлын хэлтсээс цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тухайлан тус хэлтсийн судалгааны ажлыг ялангуяа дорно дахин судлал, тэр дундаа хятад

судлалд голчлон чиглүүлэхэд онцлон анхаарч, судалгааны ажлыг нь хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбож өгөх, практикийн болон ажил төрлийн холбоотой байж болох байгууллагуудтай нягт уялдуулах, материаллаг баазыг нь бэхжүүлэх, судалгааны материал, ном хэвлэлээр хангах зэрэг ажлыг зохицуулан өгч байв.

Тухайн үед хэлтсийн судалгааны бас нэг гол чиглэл нь БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн замнал, капиталист биш хөгжлийн онол, практикийн асуудал, тухайлан Ази, Африк, Латин Америкийн шинэ залуу улс орнуудын хөгжлийн төлөв байдлыг марксист-ленинист үзэл суртал, байр сууринаас судлах явдал байлаа. Дорно дахин судлалын хэлтэс нь ийнхүү манай улсад Шинжлэх Ухааны Академийн системд Ази, Африк судлалаар анхлан “гал голомтоо” асааж, улмаар дорно дахин судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, ялангуяа XX зууны 60, 70-аад оны үеэс олон улсын тавцанд гарч ирсэн маоизмын мөн чанарыг шинжлэн судлах, манай өмнөд хөрш БНХАУ-ын тухайн үеийн эрх баригчдаас БНМАУ-ын талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл, эрдэм шинжилгээний ул суурьтай судалгаа хийх, практик ач холбогдолтой ном зохиол, өгүүллийг туурвихад гол анхаарлаа хандуулж байв.

Тухайн цаг үеийн байдалтай уялдуулан тэр үеийн социалист улсуудын Хятад судлалын төвүүдийн

³ Монгол Улсын Үндэсний Төв Архив, х-23, д-2, хн-576, х.1

эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа улам бүр өргөжиж буйг харгалзан МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1976 оны 7 дугаар сарын 2-ны 188 дугаар нууц тогтоол, мөн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 402 тоот нууц тогтоолоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх Дорно дахин судлалын хэлтсийг Дорно дахины судлалын хүрээлэн болгон өөрчлөн байгуулсан нь дорно дахины судлалын асуудлыг хөгжүүлэн бэхжүүлэх талаар тухайн үеийн нам засгаас авч явуулсан дэс дараатай, ач холбогдол бүхий үйл явдал болсныг архивын баримтад тэмдэглэн үлдээжээ.

Дээрх тогтоолын үндсэн дээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолоор гарч Дорно дахины судлалын хүрээлэнг “Хятад судлалын”, “Хөгжиж байгаа ба Хөрөнгөтөн орон судлалын”, “Хэвлэл-мэдээллийн” гэсэн 3 тасагтай, 30 хүнтэй зохион байгуулснаар хүрээлэнгийн түүхийн нэгэн шинэ үе эхэлжээ.

Дорно дахин судлалын судалгааны цар хүрээ ийнхүү өргөжин боловсон хүчнээр бэхжиж, ШУА-ийн бие даасан эрдэм шинжилгээний хүрээлэн болсноор Монгол Улсын хэмжээнд дорно дахины болон хөгжиж байгаа орон судлалын талаар хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхэлсэн шинжлэх ухааны үндсэн байгууллага, гол төв нь болсон байна.

Хүрээлэнгийн судалгааны гол цөм нь хятад судлал байж, Хятадын дотоод, гадаад бодлого, Хятад дахь үндэстний асуудлыг судлахын зэрэгцээгээр хөгжиж байгаа орнуудын улс төр,

эдийн засгийн хүрээний судалгааг уламжлал ёсоор явуулсаар байв. Энэ үндсэн хоёр чиглэлийн дагуу тус хүрээлэн тэр үеийн ЗХУ-ын болон социалист бусад зарим орны эрдэм шинжилгээний төв байгууллагуудтай судалгааны ажлаа нягт уялдуулж, ажилтнуудаа тэгш солилцооны журмаар явуулж судалгаа хийлгэх, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, судалгааны арга туршлагаас эзэмшүүлэх зэргээр хамтын ажиллагааг хөгжүүлсээр байв. 1970-аад оны сүүл үеэс БНХАУ-д хятад судлаачдын хэлний дадлага хийлгэх боломж нээлттэй болсон юм. Энэ бүхний үр дүнд энэ онуудад буюу 1980-аад оны дунд үе хүртэл Дорно дахин судлалын хүрээлэнгээс тухайн үеийн БНМАУ-ын гадаад бодлого болон олон улсын байдалтай нягт уялдсан гурав дахь ертөнцийн орнууд, капиталист биш хөгжлийн зам, БНХАУ-ын улс төр, түүх, соёл, үндэстний асуудлын талаар хэд хэдэн судалгааны бүтээл гарч, нийтийн хүртээл болжээ.

1970-1980-аад оны үед Дорно дахины судлалын хүрээлэнгийн анхааран судалж байсан нэг сэдэв бол гадаад орнууд дахь Монгол судлал, ялангуяа Монголын түүх бичлэгийн асуудал байв. Мөн үүний зэрэгцээ тус хүрээлэнгээс эрхлэн “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүлийг 1978 оноос гаргадаг болсон хийгээд албан хэрэгцээнд зориулсан “Судалгаа мэдээ”, “Танилцуулах мэдээ”-үүд нь судлаачид бүтээл туурвилаа олон түмэнд хүргэх чухал суваг болж байв. “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүл нь энэ үед манай орны үлэмж нэр хүндтэй, өргөн олон түмний унших дуртай улс төр, шинжлэх ухаан, танин мэдэхүйн

сэтгүүл болж чадсан хийгээд Монголд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн явцад нийгмийн шинжлэх ухаан, ялангуяа олон улс судлал, гадаад харилцааны судалгаа үзэл суртлын хүлээснээс ангижрахад тус сэтгүүлийн шинэлэг, хурц өгүүллүүд багагүй үүрэг гүйцэтгэж байсан гэж хэлж болно.

Дорно дахины судлалын хүрээлэн нь 1976-1980 онд БНХАУ-ын дотоод улс төр, эдийн засгийн байдал, Монгол-Хятадын эрт эдүгээгийн харилцаа, Хятадын маоист удирдагчдаас БНХАУ-ын талаар явуулж буй их гүрний дээрэнгүй бодлого, маогийнхний Зөвлөлтийн эсрэг бодлого, дэлхийн энх тайван, аюулгүй байдлын эсрэг чиглэсэн маогийнхний түрэмгий бодлогыг шинжлэх ухааны үүднээс шинжлэн судлахын зэрэгцээ Дорно дахины судлалын чухал шаардлагатай зарим асуудал, тухайлбал Төвд, Манж судлал, Энэтхэг, Япон судлал зэргийг өөрийн орны түүх, соёлын асуудалтай нягт холбон ЗХУ ба ах дүү бусад оронтой хамтран ажиллаж, Төв Азийн нүүдэлчин улс түмний түүх, соёл, Монгол ба Төв Азийн бусад орны түүх, соёлын харилцааг хамруулан судалж байв.

Энэ үеийн бас нэг онцлог бол төр засгаас Дорно дахин судлалыг хөгжүүлэхийг чухалчлан анхаарч олон эрдэмтнийг дотоод, гадаадад бэлтгэсний үрээр тус хүрээлэн мэргэжлийн боловсон хүчнээр үлэмж бэхэжсэн явдал юм. Манай орны хятад, япон зэрэг орон судлалыг олон улсын харилцааны мэргэжилтэй боловсон хүчин, эрдэмтэд бэлтгэх үйлсэд тухайн үеийн ЗХУ ихээхэн тус дэмжлэг үзүүлж ирснийг

энд онцлон тэмдэглэх ёстой. Үүний зэрэгцээ 1980-аад оны сүүлчээс эхлэн эрдэм шинжилгээний ажилтнуудыг БНХАУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг улсуудад тодорхой хугацаагаар явуулах болсон нь тэдний эрдэм шинжилгээний ажлын ур чадвар, хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа.

ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн хамт олон 1986 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар нийт 45 хүний орон тоотой, түүний дотор эрдэм шинжилгээний 38 ажилтантайгаар ажиллаж байсан бол 1990-ээд он болоход 52 хүний орон тоотой болж нэмэгдэн үүнээс эрдэм шинжилгээний ажилтан 44, захиргааны ажилтан 8-тай ажиллаж байв.

1990-ээд оны эхээр Монгол Улс, ардчилал зах зээлийн нийгэмд шилжиж, Монгол Улсын гадаад орчин эрс өөрчлөгдсөний улмаас хүрээлэнгийн судалгааны чиглэлийг бий болсон шинэ нөхцөл байдалтай уялдуулан улам боловсронгуй болгох, өөрчлөн шинэчлэх шаардлага гарсан байна.

Монгол Улсад ардчилал, зах зээлийн өөрчлөн байгуулалтын үзэл санаа хүчтэй дэлгэрэх болсонтой холбогдуулан хөрш Орос, Хятад орнуудын түүх, гадаад бодлого, орон судлалын судалгаанаас гадна дэлхийн бусад хөгжилтэй орнуудын судалгааг шинэ шатанд гарах, үзэл суртлаас ангид судлах шаардлага, хэрэгцээ буй болсон билээ. Энэ үүднээс хүрээлэнгийн орон тоонд багтаан АНУ-аас Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй бодлого, Монгол-Америкийн харилцааны түүх, өнөөгийн байдал, хамтын ажиллагааг

судлах судалгааны группийг анх байгуулж байв.⁴

Монгол Улсын гадаад бодлогын орчинд гарсан өөрчлөлт, олон улсын харилцааны шинэ хандлага төлөвийн дагуу 1990 оноос хүрээлэнгийн судалгааны чиг хандлагад зарчмын өөрчлөлт гарсан тул захирлын 1990 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн № 2 тоот тушаалаар хүрээлэнгийн бүрэлдэхүүнд 1.Ази, Номхон далайн судлалын сектор, БНХАУ, Азийн социалист орнуудын сектор, Монгол-Хятадын харилцааны түүхийн сектор, Хөгжиж байгаа орон судлалын сектор, Япон судлал, орчуулгын секторыг тус тус байгуулжээ.

Архивын баримтаас үзэхэд хүрээлэнгийн хамт олон 1990 оноос хойших хөгжлийн түүхэн замналдаа бүтэц, зохион байгуулалтын багагүй сорилттой тулгарч байжээ. Үүний тод жишээ нь, бүр 1991 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн нийт эрдэм шинжилгээний ажилтан, ажилчдын хурлаас хүрээлэнгийн нэрээ дэлхий нийтийн шинжлэх ухааны хөгжлийн хандлага, улс орны өмнө тулгарч буй өргөн хүрээний бодлого, үйл явцтай уялдуулан “Олон улс судлалын хүрээлэн” хэмээн анх өөрчлөн нэрлэхээр тогтсон⁵ боловч энэ зорилгодоо хүрч чадаагүй бөгөөд тухайн үеийн ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар 1991 оны 6 дугаар сард “Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн” хэмээн өөрчлөн зохион байгуулсан байдаг. Харин хожим нь 1997 оны 2 дугаар сард Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнг Олон улс судлалын төв болгон өөрчилж, ШУА-

ийн Түүхийн хүрээлэнд харьяалуулан бүтэц, зохион байгуулалтын хувьд нэлээд цомхотгожээ. Энэ нь 1990-ээд оны дундуур улс орны төсөв санхүүд учирсан хүндрэлтэй холбогдон төсвөөс судалгааны ажилд зориулах хөрөнгө төсвийн хэмжээ эрс багасгасантай холбоотой байв.

Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын тоо нэмэгдэж, боловсрол өндөр боловсон хүчнээр бэхжиж, судалгааны хүрээ өргөжиж байсан ч төр засгийн шийдвэрийн дагуу олон жилийн баялаг түүхтэй хүрээлэн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн, Зүүн хойд Ази судлалын төв гэсэн судалгааны бие даасан хоёр байгууллага болон хуваагдаж, өрх тусгаарлан ажиллажээ. Энэ хоёр байгууллага нь 1991-1999 онд тийнхүү тус тусдаа үйл ажиллагаагаа явуулж, удирдлага, зохион байгуулалт, санхүү-аж ахуйн хувьд бие даан ажиллаж байсан хэдий ч судалгааны ерөнхий чиглэл, зорилго, боловсон хүчний хувьд бие биеэ нөхсөн байдалтайгаар ажиллаж байв.

Эндээс үзэхэд энэ үеийн Монгол Улсын олон улс судлал, олон улсын харилцааны судалгааны бүтэц, хөгжлийн концепци тогтворжиж чадаагүй, эрдэмтэн судлаачдын харьяалагдах байгууллага байнга солигдох шинжтэй, ихээхэн ороо бусгаа байсан нь улс орны нийгэм, эдийн засгийн шилжилтийн цаг үетэй холбоотой байж, түүний хаялга нөлөө эрдэм судлалын үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлж байсныг төвөггүй ойлгож болохоор байна.

Хүн төрөлхтөн шинэ XXI зууны

⁴ Монгол Улсын Үндэсний Төв Архив, х-467, д-1, хн-38, х.55

⁵ Монгол Улсын Үндэсний Төв Архив, х-467, д-1, хн-40, х.22-23

босгоор алхан орж, дэлхийн дэг журам шинэчлэгдэх давлагаа өрнөж, шинэ бодлого, шинэ зорилт улс орны өмнө тулгарав. Олон улсын харилцааны онол, арга зүй шинэчлэгдэн дэлхий дахинаа глобалчлал, терроризм, салан тусгаарлах үзэл, аюулгүй байдал, дайн-энхийн асуудал зэргийг үнэлэх үнэлэмж, дүгнэлт эрс өөрчлөгдөж, үүнтэй уялдан олон улс судлалын цар хүрээ ч өргөжин тэлэх болов.

Иймд цаг үеийн байдал, тулгамдсан асуудлыг шийдэх түүхэн шаардлага, судалгааны хүчийг нэгтгэн нягтруулах зорилгын үүднээс “Шинжлэх ухааны зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн тухай” Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 138 дугаар тогтоолыг үндэслэн ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх Олон улс судлалын төв, Зүүн хойд Ази судлалын төвийг нэгтгэн ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнг дахин сэргээн байгуулсан байна.

Шинэ зууны эхэн үеийг угтан гаргасан энэхүү шийдвэр нь хүрээлэнгийн замнал хөгжлийн түүхийн шинэ үеийг эхлүүлжээ. Хүрээлэнгийн судалгааны сэдэв, эрдэмтэн судлаачдын бичих сэдвийн төрөл зүйл, агуулга чиглэл өргөжиж ирснээс үүдэн 1991 оноос “Дорно-Өрнө”, 1993 оноос “Зүүн Хойд Ази судлал” гэсэн хоёр сэтгүүлийг тус тусдаа нийтлүүлж байсныг нэгтгэж, 2000 оноос “Олон улс судлал” нэртэй болгон өөрчилсөн юм.

“Дорно дахин судлалын асуудал” болон дээрх хоёр сэтгүүлийнхээ шилдэг уламжлалыг хадгалахын хамт шинэ санаа, шинэ эрэл хайгуул хийж, жилд дөрвөн дугаараар нийтэлж, нийтийн

хүртээл болгож байлаа. Мөн “Монголын гадаад харилцаа” /The Mongolian Journal of International Affairs/ сэтгүүлийг англи хэлээр, “Эв мод”, “Өнөөгийн Хятад”, “Герман: Судалгаа, мэдээлэл”, “АНУ: Судалгаа, мэдээлэл”, “Энэтхэг судлал”, “Солонгос судлал” зэрэг мэргэжлийн дагнасан сэтгүүлүүдийг жилд 1-2 дугаараар хэвлэж нийтэлж байв.

ОУСХ-ийн судалгааны үндсэн зорилт нь гадаад харилцаа, олон улс судлалын асуудлаар эрдэм шинжилгээний тулгуур судалгаа хийх, мөн орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал, онол, практикийн цаг үеийн чухал асуудлыг түүх, улс төр, эдийн засаг, олон улсын эрхзүйн үүднээс судлах, энэ талаар дэлхийн бусад орны шинжлэх ухааны ололт, арга туршлагаас эзэмшин судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэхэд чиглэж байв.

Ингэснээр сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүрээлэнгээс олон улс судлал, олон улсын харилцаа, бүс нутаг судлал, Ази, Европ, Америк тивийн орнуудын хөгжлийн туршлага, Монгол Улсын хөгжлийн гадаад орчин, эдийн засгийн судалгааг гол болгох зорилт тавин ажиллажээ.

55 жилийн түүхэн хугацаанд хүрээлэнгээс Монгол Улсын төр, нийгмийн нэртэй зүтгэлтэн, эрдэмтэн, академич, доктор, профессор, дипломатч нар олноор төрөн гарчээ. Тийнхүү өнгөрөгч 55 жилд хүрээлэнгийн олон улсын нэр хүнд өсөж, жилээс жилд гадаад харилцаа тэлж, судалгааны цар хүрээ өргөжин бүтээл туурвил нь арвижиж ирсэн бөгөөд Монгол Улсын нийгмийн шинжлэх ухааны нэр төртэй салбар, манай улсын олон улс судлалын гол цөм болж чадсан байна.

Гурав. Хүрээлэнгийн судалгааны өнөөгийн байдал, цаашдын төлөв

Монгол Улсад олон улс судлал, ялангуяа хөрш орон судлал, бүс нутаг, олон талт харилцаа судлалыг улс орны үндэсний эрх ашиг, гадаад бодлогын эн тэргүүний зорилтуудтай нягт уялдуулан хөгжүүлэх нь ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судалгааны өнөөгийн үндсэн чиглэл болж байна. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд хүрсэн судалгааны үр дүнг та бүхэн бидний сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн ном бүтээл, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, зохион байгуулсан хурлууд, бэлтгэсэн бодлогын зөвлөмжүүдээс бэлхнээ харж болох юм.

Эдүгээ бид Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого, хөгжлийн гадаад таатай орчныг хангахад чиглэсэн олон улс судлал, олон улсын харилцааны судалгаа хийх, бүс нутгийн хэмжээнд судалгааны түвшин, академик мэдлэг бүтээх чадамж бүхий хүний нөөцийн чадавхаар үнэлэгдсэн, дотоод гадаадад нэр хүндтэй хүрээлэн болох алсын харааг дэвшүүлэн ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсанчлан, манай хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэл нь:

1. Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын онол, практикийн тулгамдсан асуудлыг тодорхойлох дүн шинжилгээ хийхэд идэвхтэй оролцох;
2. Хөрш улс ОХУ, БНХАУ-аас манай улсын талаар баримталж байгаа бодлого, ашиг сонирхол, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөгжлийн гадаад таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн судалгааг системтэй явуулах;

3. Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хөрш орнууддаа зөвөөр сурталчлан таниулах, дэмжүүлэх бодлогод хамаарах судалгааг үе шаттай хийх, Гуравдагч хөршийн бодлогын хүрээн дэх Гуравласан түншлэлийн механизм (Монгол-Хятад-Япон, Монгол-Орос, Герман гэх мэт)-ыг ажиллагааг хөгжүүлэх үзэл баримтлал, бодлогын судалгаа, шинжилгээ;
4. Гуравдагч хөрш хэмээн нэрлэгдсэн өрнө, дорнын хөгжингүй улс гүрнүүдээс Монгол Улсын талаар явуулж буй бодлого, ашиг сонирхол, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа хийх;
5. Олон улс, бүс нутгийн олон талт хамтын ажиллагаа, интеграцид Монгол Улсын оролцох боломж, арга замын асуудлыг судлан боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэтийн төлөвийг тодорхойлоход чиглэж байна.

Өөрөөр хэлбэл, манай эрдэмтэд Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд ОХУ, БНХАУ болон АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг «гуравдагч хөрш» орнуудын судалгаа, Ази, Номхон далайн дэд бүсийн Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азийн судалгаа, НҮБ түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын банк, санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай тогтоосон харилцаа хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Монгол Улсын үндэсний

язгуур эрх ашгийг улс төр-дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад чиглэсэн суурь судалгаануудыг хүрээлэнгийн судалгааны ажлын үндсэн чиглэл болгон стратеги төлөвлөгөөндөө тусгаж, судалгааны үндсэн чиглэлүүдээ ШУТС-ийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хянуулан баталгаажуулж, санхүүжилт авч төсөл хөтөлбөрөө үр дүнтэй, бүтээлчээр хэрэгжүүлж, төслийн үр дүнгийн тайланг жил бүр тогтмол хүлээлгэн өгч ирсэн байна.

Өнөөгийн байдлаар манай хүрээлэн нь Орос судлал, Хятад судлал, Гуравдагч хөрш орон судлал, Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлал гэсэн 4 үндсэн салбарт харьяалагддаг 34 эрдэм шинжилгээний ажилтан, 3 захиргааны ажилтан, бүгд 37 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж, нийт эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд Шинжлэх ухааны доктор (ScD)-4, Боловсролын доктор (PhD)-12, Магистр 18, эрдэм шинжилгээний ажилтны дундаж нас 40 байна. Хүний нөөц, боловсон хүчний хувьд ОХУ, БНХАУ, АНУ, Британи, ХБНГУ, Австрали, Япон, БНСУ, Турк, Вьетнам, Казахстан, Тайванд доктор, магистрын зэрэг хамгаалж, мэргэжил дээшлүүлсэн, судлаачдын ихэнх нь орос, хятад, англи, япон, герман, солонгос, турк, вьетнам, казах зэрэг гадаад хэлний чадвар эзэмшсэн тул харьцангуй өндөр түвшинд судалгаа явуулах нөөц боломж бүрдсэн хэмээн үзэж байна.

Тус хүрээлэн өнгөрсөн 55 жилийн хугацаанд олон улсын ижил төстэй үйл ажиллагаа бүхий 30 гаруй хүрээлэн, судалгааны төв, бусад эрдэм шинжилгээний байгууллагууд, Монгол Улс дахь гадаад орнуудын Элчин сайдын яамд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцан хамтран ажиллаж байна.

Бид сүүлийн жилүүдэд судалгааны үр дүнгээ Mongolia Journals OnLine (MongoliaJOL) платформоор түгээж, *Mongolian Journal of International Affairs*, Олон улс судлал эрдэм шинжилгээний сэтгүүлүүд маань хандалтаар улсаа тэргүүлж, “MongolianJol”-д бүртгэлтэй сэтгүүлүүдээс “Google Scholar”-аар эшлэгдсэн үзүүлэлтээр өндөр байж, хоёр сэтгүүл маань 2022-2023 онд DOAJ бүртгэгдсэн нь чухал алхам боллоо. Сэтгүүлийн бүх дугаар бүрэн цахимжин Монгол Улсад олон улс судлал, олон улсын харилцааны чиглэлээр мэргэжлийн хянан магадлагаа хийдэг, эрдэм шинжилгээний бүтээлийн олон улсын нэгдсэн DOI (Digital Object Identifier) дугаар олгодог салбарын анхны цахим сэтгүүлүүд боллоо.

Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн дагуу Монголын Номын Сангийн Консорциумтай хамтран www.imori.ac.mn цахим санг үүсгэн “Дорно дахин судлалын асуудал”, “Өрнө Дорно”, “Зүүн хойд Ази судлал”, “Пакс Монголика” зэрэг сэтгүүлийн 1978-2022 онд холбогдох 827 эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл болон 2000-2022 он хүртэл бүх сэтгүүлийг цахимжуулах ажлыг 2022 онд бүрэн дуусав.

Ингэснээр 2022 онд нийтдээ 2000 гаруй өгүүллийг цахим хэлбэрээр судалгааны эргэлтэд оруулаад байна. Энэ нь тус хүрээлэнгийн 55 жилийн түүхэн хугацаанд бүтээсэн эрдмийн ажлын гол үр дүн болсон олон улс судлал, олон улсын харилцаа, гадаад бодлого, түүх, нийгэм судлалын холбогдолтой нийт эрдэм шинжилгээний өгүүллийг олон нийтийн зүгээс цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр цахимаар үзэж танилцах өргөн боломж бий болголоо. Цаашид манай хамт олон олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурлын бүх эмхэтгэл бүтээлээ бүрэн цахимжуулах зорилт тавин ажиллаж байна.

Үүний зэрэгцээ хоёр талт харилцааны чиглэлээр Орос, Хятад, Солонгос, Япон судлаач эрдэмтэд маань харилцааны он дарааллын товчоон, баримт бичгийн эмхэтгэлийг ботилон гаргаж, судалгааны эх сурвалж, үнэ цэнтэй баримтыг шинээр эргэлтэд оруулсаар байна. 2019 оноос “Монголын Олон улс судлал” эрдэм шинжилгээний цуврал хурлыг шинээр санаачлан буй болгож, жил бүр тогтмол зохион байгуулж энэ хугацаанд Орос, Хятад, Япон судлалын чиглэлээр зохион байгуулж, эмхэтгэл бүтээлийг эрхлэн гаргаад байна. Манай хүрээлэнгийн эрдэмтдийн бүтээл сүүлийн жилүүдэд олон улсын нэр хүндтэй Springer Nature сүлжээгээр хэвлэн дэлхий дахинаа түгэн сурталчлагдаж байна.

Сүүлийн таван жилд манай хүрээлэнгээс дэвшүүлэн тавьж буй судалгааны үндсэн зорилт бол суурь судалгааны чанар, үр дүнг нэмэгдүүлэх

явдал болно. Энэ чиглэлээр бид цаашид ч онцгойлон анхаарч хэрэгжүүлж буй суурь судалгааны болон гадаадтай хамтарсан төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бодит үр дүн гаргахад бүх бололцоогоо дайчлан ажиллах болно.

Хамгийн чухал нь судалгааны суурь санхүүжилт, төслийн үр дүнгээр гарсан бүтээлүүдийг нийтийн хүртээл болгож судалгааны эргэлтэд оруулсан бүтээлүүдээс үзэхэд ирээдүйд чиглэсэн судалгааны сэдвийг оновчтой сонгож, судалгаанд тулгуурласан богино, дунд, уртхугацааныхөгжлийнтөлөвлөлтөднэн шаардлагатай гадаад орны туршлагыг судалж, түүнийг дотоодын чадавхтай уялдуулан ашиглахад дөхөм үзүүлэхүйц санал зөвлөмж боловсруулж, гадаад бодлогын зорилго, зарчим, тэргүүлэх чиглэлийн судалгаанд голлон анхаарах зүйтэй байна. Өнөөгийн байдлаар хоёр хөршийн хил орчмын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, зах зээлийн багтаамж, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж зэрэг олон хүчин зүйлийг тандан судалж, түүнийг эдийн засгаа бүсчлэн хөгжүүлэх үндэсний бодлоготой нягт уялдуулах, цаашлаад Монгол Улс ямар орон зайд багтах, хэнтэй эвсэх, хэнийг дагах, гол нь бүс нутгийн ямар бүтэц, байгууллага, форумд очиж элсэн интеграцчилагдах гэх мэт тулгамдсан асуудлуудад судалгааны ажлаа төвлөрүүлж ирлээ.

Манай эрдэмтэн судлаачдын судалгааны үндсэн чиглэлээс үзэхэд төр засгийн бодлогын шийдвэр гаргалтад тусгалаа олохуйц судалгааны үндэслэлтэй бодлогын зөвлөмжүүд боловсруулж, нийгмийн хөгжил, эдийн

засгийн өсөлтийн хэтийн бодлогыг гадаад орчны эгзэгтэй, ээдрээ төвөгтэй, эрс хурдан хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн олон улсын геополитикийн хурцадмал байдал, дижиталчлалын эриний хөгжлийн шинэ үйл явцтай нягт уялдуулсан онол, практикийн

ач холбогдолтой бүтээл туурвилууд зонхилж байгаа нь тус хүрээлэнгийн өнөөгийн эрдмийн хамт олон төр засгийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж буйг нотлон харуулж байна.

Дөрөв. Дүгнэлт, санал

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн 55 жилийн судалгааны түүхэн хандлага, өнөөгийн үйл ажиллагааны талаар нэлээд тоймлон авч илтгэлээ. Миний илтгэлийн дүгнэлт, саналын хэсэгт Монгол Улс дахь олон улс судлалын цаашдын төлөв, чиглэл хөгжлийн талаар Та бүхэнтэй илүү саналаа солилцохыг хүсэж байна.

Өөрөөр хэлбэл, миний илтгэл нь манай эрдмийн хамт олны 55 жилийн түүхэн хугацаанд хүрсэн ололт амжилт, анхаарах судлах онцлог зүйлсэд тулгуурлан хүрээлэнгийн судалгааны хүрээнд авч үзсэн боловч дүгнэлт, саналаа би Монгол Улс дахь олон улс судлал буюу гадаад орон судлалын хүрээнд, энэ салбарын цаашдын хөгжлийн төлөв хандлагатай уялдуулан илүү өргөн хүрээнд авч үзэхийг хичээлээ.

Бидний харж байгаагаар Монгол Улс дахь олон улс судлалыг цаашид хөгжүүлэхэд дараах хэд хэдэн тулгамдсан асуудал оршиж байна гэж дүгнэж, энэ хүрээнд зарим тодорхой саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон улс судлал, гадаад орон судлалыг төрийн гадаад бодлогын төлөвлөлтэй нягт уялдуулах, ГХЯ-наас захиалгат сэдэв, судалгаа, төслүүдийг

зарлах, түүнд эрдэмтдийг оролцоог ханган оролцдог байх нь чухал юм. Үүний тулд төр засаг, судалгааны байгууллагын харилцан ойлголцол, эргэх холбоо, удирдлага менежментийг сайжруулах нь чухал болж байна.

2. Монгол Улс дахь Орос, Хятад судлалын салбарыг шинэ залуу, чадварлаг боловсон хүчнээр сэлбэн бэхжүүлэх, энэ чиглэлийн залуу эрдэмтдийг тогтсон дэг сургуулийн дагуу их, дээд сургуулиудтай хамтран үе шаттай бэлтгэх, сургалт, судалгааны хөтөлбөрийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх, мэдээллээ солилцох сувгийг өргөжүүлэх, оюутан, залуу судлаачдад чиглэсэн олон талын дэмжлэг бүхий тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Цаашид судалгааны төлөвлөлтийн хувьд уламжлалт хоёр талт харилцаанаас олон талт харилцаа руу шилжиж, бүс нутгийн хамтын ажиллагааны интеграцийн дагуу судалгааны бүтээл, төслүүдээ уялдуулан ажиллах шаардлага тулгарч байна. Үүний тулд олон улс судлалыг хөгжүүлэхийн тулд байгаль-нийгмийн ухааны бусад судалгааны хүрээлэн, төв, их, дээд сургуулийн зорилго, агуулгын

давхцал бүхий судалгаанд хамтран оролцох байдлаар өнөөгийн хүрээ, хязгаарыг илүү тэлж, өргөжүүлэх бодит шаардлага байна.

4. Манай улсын хувьд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд зөвхөн төвлөрч буй олон улс судлалын судалгааны чиглэл, хүний нөөцийн боломжийг их, дээд сургуулиудын адил чиглэл бүхий гадаад орон судлалын хөтөлбөрүүдтэй уялдуулах, аль чиглэлийн ямар судалгааг “олон улс судлал”, “гадаад орон судлал” хэмээн үзэх хүрээ хязгаараа зөв оновчтой тодорхойлох, түүх, хэл, соёл, утга зохиолоос эхлээд өргөн хэмжээнд бүгдийг “гадаад орон судлал” руу хандуулсаар ирсэн өнөөгийн бодит байдлаа эргэн харах, үүний тулд энэ чиглэлийн онол, арга зүйн үндэслэлийг бататгасан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, сургалт, семинарыг тогтмолжуулан зохион байгуулах нь бидний цаашдын судалгаанаас гарах үр дүнд чухал ач холбогдолтой хэмээн дүгнэж байна.

Илтгэлийнхээ төгсгөлд, Монгол Улсын олон улс судлалын гол цөм болсон ШУА-ийн ууган хүрээлэнгүүдийн нэг Олон улс судлалын хүрээлэнгийн 55 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан ёслол хүндэтгэлийн арга хэмжээ болон “Монгол Улс дахь олон улс судлалын өнөөгийн байдал, хөгжлийн хандлага” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Гадаад харилцааны яамны удирдлага, хамт олонд гүн талархал дэвшүүлж байна.

“Дэлхийн шинжлэх ухааны өдөр” зохион байгуулагдаж буй манай

хүрээлэнгийн 55 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд оролцож буй хүрээлэнгийн үе үеийн эрдэмтэн судлаачид, бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн хүндэт зочид та бүхэндээ эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөж, баяр мэнд дэвшүүлж байгааг хүлээн авна уу.

Монголын олон улс судлал өргөжин тэлж, үйл бүтээл ундарч байх болтугай.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

“Монгол Улс дахь олон улс судлалын өнөөгийн байдал, хөгжлийн хандлага” эрдэм шинжилгээний хурал,

Гадаад харилцааны яам,

“Зөвшилцөл” танхим, 2023.11.10

Historical approach of international studies in Mongolia, current state and future outlook (on the example of the Institute of International Studies of MAS)

Zolboo Dashnyam

Ph.D

Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,

Ulaanbaatar, Mongolia

zolbood@mas.ac.mn

Abstract: *The Institute of International Studies of the Mongolian Academy of Sciences, which is the oldest professional academic organization as 'Think-Tank', that exclusively carries out basic research on international studies and international relations in Mongolia, was established 55 years ago amid hard external and internal conditions of the country, and had gone through several stages.*

The main purpose of this report is to summarize the main research results of the Institute of International Studies of MAS for latest 55 years, and to briefly present to you my brief conclusions and suggestions about the current state and future prospects of international studies research. The paper has consisted following parts, a. Historical background of the institution, b. A historical approach to institute research, c. Current status and future prospects of the Institute's research, d. conclusion and some proposals etc.

The day of submission: 2023.11.10

Completion of review: 2023.12.11

Final decision for acceptance: 2023.12.20